

ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН СЭТГЭЦИЙН ҮЗЭГДЛИЙГ ПРОЕКТИВ АРГААР СУДЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

А.Ичинхорлоо, магистр
МУБИС-ийн Ар.БС-ийн Бага боловсролын тэнхимийн багш
Т.Норовсүрэн, магистр
Боловсрол судлалын тэнхимийн багш

Abstract: Nowadays we need different communication skills in life so it is necessary for young people to have many skills. On this regard, we need to pay attention on how to develop children mentally concentrating on their mental phenomena from the first day of school. Mental process of six-year old children is closely connected with intellectual mind, character and psychology. To fulfill this action successfully is the role of primary education teachers and organization as well. To control children's mental phenomena, the teacher needs to use basic research methods of psychology with projective methods. Projective methods are easy to elaborate the word tests. Projective methods can be the main resource of primary education teachers and parents. Teachers usually use research methodology by analyzing children's works and writings. So they need to use projective tests to study mental phenomena of young children. In our research we discovered that it is possible to use the Rorschach inkblot test, the Wartegg Zeichen test, and the apperception test. Our research gives the opportunities to study mental phenomena of six-year old children.

Түлхүүр үг: Роршахын сорил, апперепцийн сорил, зурган сорил, хөрөг зураг

Удиртгал

Монгол улсад хүүхдийг зургаан наснаас нь ерөнхий боловсролын сургуульд элсүүлэн сургаж байгаа нь боловсролын салбарт төдийгүй үндэсний хэмжээнд хүний хөгжлийн асуудлыг шийдэх

нэг чухал асуудал болж байна. Үүний эх булаг нь зургаан настай хүүхдийн хөгжлийн асуудлыг зөв удирдах, цаашид тэднийг амжилттай суралцах нөхцлийг бүрдүүлэхийн тулд тэдний сэтгэцийн үзэгдлийг судлах шаардлага гарч байна. /Бага ангийн хүүхдийг судлахад зориулсан суурь аргачлалууд нь бичгээр гүйцэтгэх зааварчилгатай сорил байдаг учраас зургаан настай хүүхдийг оношлох, эрэлт хэрэгцээг тодорхойлж чанартай боловсролыг бий болгоход хүндрэлтэй үүнтэй холбоотойгоор хүүхдийг проектив аргаар судлах боломжийг судлав./

Сэдвийн судлагдсан байдал

Бага насны сэтгэцийн хөгжлийг судлах асуудлаар А.Гезеллийн сургуулийн хуримтлуулсан судалгаа шинжилгээний туршлагад суурилж Ш.Бюлер, Г.Гетцер нар 1930-1940-өөд онуудад ихэд түгэн дэлгэрсэн өөрсдийн аргачлалыг /1-6 насны хүүхдийн мэдрэл-сэтгэцийн хөгжлийг үнэлэх сорилууд, Сүүлийн жилүүдэд Өрнөдийн улс орнуудад бага насны оношилгоонд Н.Бейлийн боловсруулсан хэмжүүрийг /bayley Scales of infant development/ өргөн хэрэглэж байна. Оросын нэрт сэтгэл зүйч Л.С.Выготский "...хүүхэд сургуульд элсэн суралцахдаа юм огт бичээгүй цагаан цаас шиг бэлтгэгдээгүй орж болохгүй" хэмээн сургуульд бэлтгэх нэгэн чухал үе шатыг зайлшгүй дамжин элсэхийн чухлыг онцолжээ. Энэ талаар сэтгэл зүйч Е.Е.Кравцова, Л.М.Мухина, Л.С.Кравцова зэрэг олон эрдэмтэд судалсан байдаг.

Бид энэхүү өгүүлэлдээ зургаан настай



хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг проектив аргаар судлах хэрэгцээ, шаардлагыг тогтоох, арга зүйг боловсруулж туршилт судалгаа явуулах зорилгыг тавив.

- Судалгааны ажлыг дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлээ.
- Оюутан-багш зургаан настай хүүхдийг проектив аргаар судлах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох
- Зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг проектив аргаар судлан тодорхойлох арга зүйг боловсруулах, /Зургаан настай хүүхэд дээр туршилт явуулах/
- Бага ангийн судлаач багшийн үүргийг нэмэгдүүлэх арга замыг сайжруулах

Судалгааны арга

Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализийн аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулахад, асуулгын аргыг 6 настай хүүхдийн сэтгэцийн хөгжлийг тогтооход, ярилцлагын аргыг туршилтын явцад хүүхэд, багштай хамтран ажиллахад болон туршилтын үр дүнг тодруулахад, ажиглалтын аргыг туршилтын явцад хүүхдийн хөгжилд гарч буй өөрчлөлтийг баримтжуулахад, статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхэд тус тус хэрэглэв.

Судалгаанд бага ангийн багш болон багшлах дадлагын үеэр зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг оношилсон оюутан-багш. Мөн туршилт судалгааг хийхэд бага боловсролын зургаан настай хүүхдүүд хамрагдав.

Энэхүү судалгаанд зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг проектив аргачлалаар судалж, гарсан үр дүнд тулгуурлан дүгнэлт хийлээ.

Зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийн хөгжлийг судлах аргачлалтай болсноор ЕБС-ийн бага ангийн багш нарт

төдийгүй эцэг, эхчүүдэд арга зүйн чухал хэрэгцээт материал болох болно.

1. Зургаан настай хүүхдийн сэтгэцийн онцлогийн талаарх ойлголт

Өнөөдөр олон хүүхэд бие бялдар, нийгэмшихүй, сэтгэл санаа, танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдолтойгоор сургуульд орж байна. Эдгээр хоцрогдлыг хүүхэд ба гэр бүлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрт анхаарч ажиллаж чадвал багасгаж болно. Гэр бүл, сургууль, цэцэрлэг, орон нутгийн засаг захиргааны байгууллага нь бага насны хүүхдийн бие бялдар, нийгэмшихүй, сэтгэл санаа, хэл яриа, уншиж бичих чадвар, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих орчин нөхцөлөөр хангах боломжийг олгохгүй бол хүүхдүүдийн сурч боловсрох үйл ажиллагаанд хүндрэл үүснэ. Зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийн хөгжил хэмээх ойлголт нь олон хүчин зүйлээс шалтгаалах цогц асуудал бөгөөд хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

- Хүүхдийн сэтгэцийн процесс: Сэрэл, хүртэхүй, ой тогтоолт, сэтгэхүй, хэл яриа
- Хүүхдийн хувийн онцлог шинж: Авир араншин, зан төлөв, авъяас, сонирхол
- Багшийн бэлтгэл хангасан байдал

Бага сургуулийн багш нар хүүхэд насанд хүрэгчдийн зааврыг дагаж мөрддөг, ангид сахилга баттай байх, бусдын сэтгэл хөдлөлд мэдрэмжтэй ханддаг, хэрэгцээ, санал бодлоо ойлгуулж чаддаг, шинэ үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх нь чухал гэж үзсэн байна. Манай улс боловсролын шинэ тогтолцоонд шилжиж “Зургаан наснаас сургуульд суралцах болсноор бага ангийн багш хүүхдийн сэтгэцийн онцлогт тохирсон боловсролыг олгох нь нэн чухал хэмээн үзэх болсон тул 6 настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг хэмжих нь оновчтой гэж үзжээ” (Зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааны тайлан, 2008).

Үүнд:

- Оюун ухаан, танин мэдэхүй
- Нийгэмшихүй, сэтгэл хөдлөл, айдас түгшүүр

Эдгээр чиглэл нь хүүхдийн сэтгэцийн хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд бөгөөд өөр өөрийн онцлогтой боловч хоорондоо харилцан шүтэлцээтэй, бие биедээ нөлөөлж байдаг.

Өнөөгийн бага ангийн багш проектив арга эзэмших хэрэгцээ, шаардлага

Өнөөгийн нийгэмд хүний амьдрал улам бүр олон талтай болж байгаа нөхцөлд нас биед хүрч байгаа залуучуудаас олон төрлийн чадвар шаардах болсон учир хүүхдийг сургуульд орсон цагаас нь эхлэн сэтгэцийн үзэгдлийн хөгжилд байнга хяналт тавих хөгжүүлэх асуудлыг онцгойлон анхаарах хэрэгтэй болж байна. Зургаан настай хүүхдийн сэтгэцийн хөгжил нь оюун ухаан, зан харилцаа, сэтгэл зүй зэрэг олон зүйлийг хамарсан өргөн агуулгатай үйл явц юм. Энэ үйл явцыг амжилттай хэрэгжүүлэх нь бага ангийн багшийн үүрэг төдийгүй, бага боловсролын байгууллагын үүрэг юм. Бага ангийн багш хүүхдийн сэтгэцийн үзэгдэлд хяналт тавихын тулд сэтгэл судлалын судалгааны суурь аргуудыг проектив аргачлалтай хослуулан ашиглах хэрэгцээ чухлаар тавигдаж байна.

Проектив аргын онцлог

Проектив аргаар зургаан настай хүүхдийн сэтгэл хөдлөлийн илрэл, түүний хүртэхүй, мэдрэмж, үг яриа, хөдөлгөөн нь түүний хувийн онцлогийн илрэл болдог. “Психоанализын үзэл баримтлалын дагуу проекц нь хамгаалалтын механизмын нэг бөгөөд түүний тусламжтайгаар “Би”-д нийцэхгүй дотоод түлхэц, мэдрэмжийг гадаад объектод тохон буулгаж, хүрээлж буй ертөнцийн өөрчлөгдсөн хүртэхүй хэлбэрээр ухамсарт нэвтрэн ордог байна” (Туяа.Б 2011,х.81) хэмээн тодорхойлжээ.

Судалгааны хэсэг: Асуулгын арга

Зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг проектив аргаар судлах хэрэгцээ,


шаардлага байгаа эсэхийг тогтоох судалгаа

Судалгааны объект: ЕБС-ийн бага ангийн багш болон Архангайн багшийн сургуулийн бага ангид багшлах дадлага хийсэн оюутан-багш нар хамрагдав.

1. Таны сонгож авсан судалгааны арга зургаан настай хүүхдийн нас сэтгэцийн онцлогт тохирч байна уу?

а. Тийм-38.5% б. Үгүй-61.5%

Диаграмм-1



Дээрх судалгаанаас харахад зургаан нас хүүхдийн сэтгэцийг оношлоход баримтлах ёстой зарчим зөрчигдөж байгаа нь харагдаж байна. Энэхүү байдал нь тухайн хүүхдийн нас сэтгэцийн онцлогт тохирсон аргачлал байхгүйтэй холбоотой. Иймээс проектив аргыг ашиглах шаардлага урган гарч байгааг харуулж байна.

2. Та бага ангийн хүүхэд судлах судалгааны ямар аргуудыг мэдэх вэ? Нэрлэнэ үү.


- Хүүхдийн оюун ухааныг үнэлэх /Wechsler Bellevue scale/, Оюун ухааны хөгжлийн түвшин Равены өсөх матриц /Raven Progressive Matrices/
- Анхаарлын багтаамж, хуваарчлалтыг судлах аргачлал
- Ой тогтоолтыг судлах аргачлал
- Юнгийн сэтгэцийн хэв шинжийг судлах аргачлал
- Векслерийн хэмжүүр /Wechsler Memory scale, WMS/

- Дээрх судалгааны нээлттэй асуултанд дүн шинжилгээ хийж үзвэл дээрх судалгааны аргууд нь тухайн улс орны нийгэм-соёлын ялгаатай холбоотой багагүй бэрхшээл тулгардаг. Сорил зохиогдсон тухайн нийгэм-соёлын өвөрмөц онцлог, зан заншил,




уламжлал, үнэт зүйлс зэрэгтэй холбоотой бэрхшээл тулгардаг иймд проектив аргыг хэрэглэх боломжтой.

2. Таны судалгааны явцад саад бэрхшээл учирдаг уу? Ямар бэрхшээл байгааг нэрлэнэ үү



Дээрх нээлттэй асуулгаар зургаан настай хүүхдийг судлахад тулгамдаж буй бэрхшээлүүдийг илрүүлсэн бөгөөд энэ нь тухайн насны хүүхдэд зориулагдсан сорил боловсруулагдаагүй байгаагаар холбоотой. Тухайн сорил нь үгэн хэлбэрээр байдаг учраас өөрөө бие даан хариулах боломжгүй, мөн зарим үг ойлгомжгүй, ихэнх сорилууд бичгээр боловсруулагдсан учраас хүүхдийн сонирхол амархан буурдаг эдгээр үндсэн шалтгааны улмаас судалгааны явцад бэрхшээл үүсч байв.

3. Та зургаан настай хүүхдийн сэтгэцийг оношлохдоо проектив аргыг хэрэглэж байсан уу?



Судлаач багш нь проектив аргачлалын талаар ойлголттой байснаар зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдэлд гарч буй өөрчлөлтийг судлах боломжтой бөгөөд хүүхдийн зан үйлийн онцлог танин мэдэх чадвар хөгжлийн түвшинд тохируулан сургалтаа явуулахад тустай юм.


Судалгааны туршилтын хэсэг

Зургаан настай хүүхдийн сэтгэцийн хөгжлийг оношлох туршилт судалгааг Архангай аймгийн Багшийн сургуулийн Бага ангийн багшийн мэргэжлийн дадлагаар сэтгэц оношилгооны судалгааг сонгож, дараах туршилт судалгааг явууллаа.

Зургаан настай хүүхдийг судлах хамгийн энгийн проектив арга бол

- Вартеггийн зурган сорил (Wartegg Zeichentest, 1953)

Аргачлалын хэрэглэгдэхүүн хар өнгийн талбайд цагаан өнгийн орон зайгаар хүрээлэгдсэн стандарт 8 график дүрслэлээс бүрдэнэ.



Даалгаврыг хийж гүйцэтгэсний дараа судлуулагч хамгийн сайн болон хамгийн муу зурсан зургаа нэрлэж, зурсан зураг нь ямар агуулгатай, юуг илэрхийлж байгаа тухай асуултанд хариулна. Сорилтой холбоотой судалгаанд оролцсон зургаан настай хүүхдийн зургийн жишээг авч үзье



Children.1 psy

Дүгнэлт: Дээрх судалгаанаас үзэхэд энэхүү хүүхэд нь уян зөөлөн, тодорхой бус, сэтгэл хөдлөл ихтэй, хөөрөл давамгайлсан аливаа үйл ажиллагаа нэгэн хэвийн хийж гүйцэтгэх дуртай мэдрэмж багатай, уриалгахан чанар давамгайлсан, харьцангуй нээлттэй хэв шинжийн хүүхэд болох нь харагдаж байна.

Роршахын тест. 1921 онд Г.Роршах боловсруулсан. Сэтгэц оношилгооны судалгаанд ихэд түгэн дэлгэрсэн аргачлалын тоонд ордог.

Роршахын сорилын хэрэглэгдэхүүн хэлбэржээгүй хар-цагаан болон өнгөт тэгш хэм стандарт 10 дүрсээс /Роршахын толбо/ бүрдэнэ.


Толбо 1. Роршахын сорил



Толбо 2. Роршахын сорил



Толбо 3. Роршахын сорил



Толбо 4. Роршахын сорил



Дээрх дүрсүүдийг ашиглан судалгаа явуулахад туршилтад орсон зургаан настай хүүхэд 15 секундэд бодит байдлыг хүртэн таньж дүрслэлийн хэлбэрийг зохистой тусгасан зургийг одоо байгаа байрлал нь /толбо №1 / бамбарууш, нохой, усны дусал, амаа ангайж буй мангас, барын толгой, муур, ярилцаж байх явцад ярьсан зүйлээ мартах, огцом үйл хөдлөл гаргаж байв. Тухайн зургийн талаар өөрийн саналаа идэвх зүтгэлтэй хэлж байсан. Тогтворгүй хүүхэд байсан бөгөөд сонирхол нь амархан буурч байгаа нь харагдаж байсан бөгөөд судлаач багшийн заавраар бус дараагийн зураг юутай төстэй болохыг тайлбарлаж эхэлсэн.

/Толбо №2/ 8 секунд мангас шиг, эрвээхэй, могой, сарьсан багваахай, хүн, үндэс гарсан мод шиг, улаан хэсгээс шувуу шиг, далайн хавч, амьтан явсан мөр.



/Толбо №3/ 30 секунд дээр хар хэсэг уулан дээрх мод, нүхнээсээ гарч ирж буй хулгана

/Толбо №4/ 10 секунд аалз, ургамлын үндэс, хоёр сармагчин, намрын унаж буй навч, цэцэг, доод талд байгаа ногоон хэсэг хорхой, дотор талын улаан гэр.

Дээрх зургаан настай хүүхдийн хариулсан хариултад дүн шинжилгээ хийж үзэхэд аливаа зүйлийг хурдан хүртэж таних чадвартай, эхлээд бодохгүй ярих тохиолдол гарч байсан, бөгөөд их яриа нээлттэй, дүрслэлийн ой тогтоолт сайн хөгжсөн, бүтээлч өвөрмөц хариултыг өгч байсан. Мөн хүрээлэн буй ертөнцийн талаар өөрийн гэсэн ойлголттой, аливаа зүйлд оюун дүгнэлт хийх чадвартай нь харагдаж байв.

Хүүхдийн апперцепцийн сорил

1949 онд Л.Беллак, С.Беллак нар энэхүү проектив аргыг хэвлүүлж олны хүртээл болгосон байдаг. САТ нь сэдэвт апперцепцийн сорилын хувилбар бөгөөд 3-10 насны хүүхдийг судлах зориулалтай хүүхдийн сорил юм.

Зураг 1



Зураг 2



Зураг 3



Зураг 4



Судалгааны объект. Аав, ээж, эгчийн хамт амьдардаг, 6 настай, шатар тоглох дуртай

Дээрх проектив аргаар гэр бүлийн гишүүдийн хоорондын харьцаа хандлага тодорхойлж үзвэл.

Судалгаанд оролцогч /Зураг №1/ зургийг дүрслэхдээ, Аав нь ээж, хүү хоёрын эсрэг татаж буйгаар дүрсэлсэн бөгөөд энэ байдал нь харилцааны хувьд аавтайгаа зөрчилтэй, мөн сэтгэл дундуур байгааг илтгэж байна. Дараагийн зураг руу их хурдан шилжиж байсан бөгөөд энэ байдал нь хүүхдийн анхаарал болон сэдлийг маш сонирхолтой зураг анхаарлыг нь татаж байгааг харуулж байна.

Зураг /№2/ Дээрх зургийг дүрслэхдээ аав нь хүүгээ загнаж толгой руу нь цохиж байна, Ээж нь охиндоо юм хэлж байна. Аав ээж 2 нь өөр тийш харсан байдлыг тайлбарлахдаа ээж нь аавыг нь загнаад байгаа болохоор зөвхөн хүүтэйгээ ярилцаж байгаа гэсэн тайлбарыг хийсэн. Гэр бүлийн гишүүдийн хоорондын зай байрлал, тэдний харьцаа хандлагын

онцлогийг илэрхийлж байдаг. Иймээс сэтгэл зүйн хувьд ойр дотно байдлыг илэрхийлэгч нь гол төлөв зай байдаг учраас аавтайгаа дотно байхыг хүсдэг. Мөн аав ээж 2 нь бие бие рүүгээ харахгүй байгаа нь тэдгээрийн дунд зөрчил байгаа нь харагдаж байна. Харин ямар нэгэн ажлыг гэр бүлийн гишүүд тус тусдаа хийж байгаагаар дүрсэлж ярьж байгаа нь гэр бүлийн дотор үзэл бодлын зөрөлдөөн, зөрчил, дотоод бүлэглэл байна гэж тайлбарлаж болох юм. /Гэр бүлийн хөрөг” зурган сорилын жишиглэлтэй харьцуулан тохирц чанарыг баталгаажуулж үзлээ./

ДҮГНЭЛТ

Дээрх судалгааны асуулга болон туршилтаас харахад бага ангийн оюутан-багш нь чанартай боловсролыг бий болгохын тулд бага ангийн хүүхдийн танин мэдэхүйн онцлогийг оношлон эрэлт хэрэгцээг судлан тодорхойлж түүнд тохирсон боловсрол олгох нь чухал.

Иймээс өнөөгийн хэрэгцээ шаардлага бол ЕБС-ийн зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг судлахдаа проектив аргыг суурь аргуудтай хослуулан судалгаа явуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Ингэснээр хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг тодорхойлж хөгжлийг зөв удирдах, мөн тохирсон арга барилаар ажиллах боломж нээгдэнэ. Ялангуяа бага ангийн багш зургаан настай хүүхдийг судлахад ашиглах боломжтой вартегт “Зурган сорил”, “Раршахын толбо”, “Хүүхдийн апперепцийн сорил” зэрэг аргачлалыг ашиглан зургаан настай хүүхдийн сэтгэцийн хөгжлийн үйл явц, шинжийг судлах боломжтой нь туршилтаас харагдлаа. Ийнхүү сорилоор сэрэл, хүртэхүй, авир араншин, сэтгэл хөдлөл, гэр бүлдээ болон бусдад хандах хандлага, тэдний зан үйл, сэдлийг илрүүлэх боломжтой.

Эдгээр проектив аргачлалыг бага насны хүүхдийг судлах мөн судлаач сонирхож буй асуудлаар илүү нарийвчилсан мэдээллийг олж авах боломж олгодог.

Энэхүү судалгаанаас бага ангийн багшийн үүргийг дээшлүүлэх, ажлыг улам боловсронгуй болгох санал:

- Зургаан настай хүүхэдтэй ажиллаж буй багш нар анги удирдах урлаг, хүүхдийн сэтгэл зүйн онцлогийн талаар ном зохиол уншиж судлан, ажилдаа хэрэгжүүлэхээс гадна хичээлийн сэдэв, зорилготой уялдуулан хүүхдийн насны онцлогт тохирсон сурган тоглоом зохиож сургалтандаа хэрэглэх чадвартай байх хэрэгтэй.
- Зургаан насны хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг үнэлэх “Зургаан настай хүүхдийг судлах проектив аргачлал”-аар үнэлэх энэ аргыг цаашид Бага боловсролын сургалтанд нэвтрүүлбэл үр дүнгээ өгнө гэж үзэж байна.
- Бага ангийн багш нар “Хүүхдийн сэтгэцийн хөгжлийн хяналтын дэвтэр”-ээр хүүхдийн сэтгэцэд гарч буй өөрчлөлтийг ажиглалт хийн тэмдэглэл хөтлөж, хүүхдийн хөгжлийн явц, хандлага, ахицыг бодитой үнэлэх
- Багш нар хүүхдийн сэтгэцийн хөгжилд гарсан ахицыг эцэг эхэд нь мэдээлдэг байх
- Сэтгэл судлаач нар Зургаан настай хүүхдийн сэтгэцийн үзэгдлийг оношлох энгийн болон проектив аргачлалыг хэрэглэх арга зүйг бага ангийн багш нарт түгээн дэлгэрүүлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батдэлгэр, Ж. (1994). *Сургуульд хүүхдийг бие хүний талаас бэлтгэх сэтгэл зүйн үндэс*. Улаанбаатар
- Батдэлгэр, Ж., Оросоо, Ш. (1999). *Бага насны хүүхдийн бие бялдар-сэтгэцийн хөгжлийн онцлог*. Улаанбаатар.
- Батдэлгэр, Ж., Монгол хатан, Г. (2009). *Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх арга зүй*. Улаанбаатар.
- Заяа, С. (2009). *Бага насны хүүхдийн хөгжил*. Улаанбаатар.



- Монгол Японы шинжлэх ухаан хамтын ажиллагааг дэмжих. (2008). Бага насны хүүхдийг хөгжлийн стандартын төсөл. Монгол: Согоо нуур
- Наранчимэг, Н., Увш, П. (2001). *Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтны гарын авлага*. Улаанбаатар.
- Норжхорлоо, Н. (2001). *Бага насны хүүхдийн хөгжил*. Улаанбаатар.
- Туяа, Б. (2011). *Сэтгэц оношилгооны тайлбар толь*. Улаанбаатар.
- Bellak.L ,Bellak.S Children apperception test <http://www4.parinc.com/Products/Product.aspx?Product> available at.
- Главная. Психологические тесты <http://online-test.com.ua/character/rorshah> available at.